



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/02

Чойр

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод коронавируст халдвар “Ковид-19”-ын гарал үүсэл нь тодорхойгүй голомт шинээр үүсэж, халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан нийслэл хотоос ирэх иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулах үүднээс замын хөдөлгөөний хяналтын цэгийг нэмж байгуулсугай.

2. Хяналтын цэг нэмж байгуулж байгаатай холбогдуулан гарах зардлыг нэгдүгээр, нийслэл хот болон бусад аймаг руу зайлшгүй шалтгаанаар зорчих иргэдэд зөвшөөрөл олгох нөхцөл шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Эрүүл мэндийн Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга /хурандаа Н.Чанцал/, Эрүүл мэндийн газрын дарга, Шуурхай штабын менежер /Ц.Мөнх-Од/ нарт үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон, албан хаагч бүрийг томилгоожуулан ажил үүргийн хуваарийг баталж, ажлын сахилга бат, үүрэг хариуцлагыг өндөржүүлж ажиллахыг бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4212100003

5. Конавируст халдвар "Ковид-19"-ын зөөвөргөдсөн тохиолдол

бүртгэгдэхээс сэргийлж, эрсдэлт бүлэг, албан байгууллага, үйлчилгээний газруудын ажиглалтад идэвхтэй тандалт судалгаа хийхийг Эрүүл мэндийн газрын дарга

И.Мөнх-Од-д даалгасгай.

6. Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас тус аймагт

зорчин ирж байгаа бүх иргэн РСР шинжилгээний харуу гарсан өдрөөс хойш 48 цагийн дотор нэвтрэх бөгөөд ирсэн өдрөөс эхлэн өөрийгөө 7 хоног тусгаарлан,

далтам мөрдөхийг үүрэг болгосгай.

7. Хяналтын цаг ажиглуулахад шаардгдах 3 861 036 /гураван сая найман зүүн

жаран нэгэн мянга гучин зургаан/ төрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном-д

зөвшөөрсүгэй.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг аймгийн Засаг даргын

орлогч, аймгийн Онцгой комиссын орлогч дарга /Б.Анхбаяр-д, захирамжийн хэрэгжилтийг тайлагнаж ажиглахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой

комиссын орлогч дарга /хурандаа Н.Чанцал-д тус тус үүрэг болгосгай.



ЗАСАГ ДАРГА Г.БАТЗАМ